

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/143/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг:
tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Л.Мандахнаран

Утас: 92118277 Цахим хаяг:
MandakhnaranL@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
4. Аудитын тайлан.....	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймгийн 03.27 № 01/308
танай _____-ны № _____-т

ШИНЭ-ИДЭР СУМЫН ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ
М.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Шинэ-Идэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинэ-Идэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэн нэгтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага 108.2 сая төгрөг байна. Хоршоо хөгжүүлэх сангийн 23 иргэний 69.5 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Шинэ-Идэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч Хөвсгөл аймгийн Засаг даргатай тайлант онд 14 чиглэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллахаар гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг 90 хувиар дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

		/Мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	937,010.1	406,182.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	264,975.1	205,507.0
33	АВЛАГА	235,661.8	123,816.3
35	БАРАА МАТЕРИАЛ	436,373.2	76,859.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	11,733,387.0	2,167,819.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,733,387.0	2,167,819.4
39200	Биет хөрөнгө	11,564,288.8	2,124,502.9
39300	Биет бус хөрөнгө	169,098.2	43,316.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	12,670,397.1	2,574,002.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,035.1	5,680.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,035.1	5,680.0
41300	Өглөг	2,035.1	5,680.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12,668,362.0	2,568,322.2
51	Засгийн газрын хувь оролцоо	12,668,362.0	2,568,322.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,667,335.6	953,041.1
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,667,335.6	953,041.1
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,137,093.0	687,676.4
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	10,407.5	24,539.5
51200	Хуримтлагдсан үр дүн	7,416,155.2	378,427.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,437,370.7	524,637.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	12,670,397.1	2,574,002.2

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

		/Мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,058,658.9	880,297.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	133,547.4	306,891.1
110	Орлогын албан татвар	61,081.3	228,873.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	61,081.3	243,779.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-14,906.3
113	Хөрөнгийн албан татвар	37,917.5	46,666.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	34,548.5	31,351.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,564,142.1	-331,487.5
120	Нийтлэг татварын бус орлого	3,564,142.1	-331,487.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,360,969.4	904,893.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,890,647.6	933,440.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,890,647.6	933,440.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,693,647.3	929,283.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,949,906.0	382,207.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	251,972.2	47,986.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	477,213.8	74,623.1
2104	Хангамж, бараа материалын зардал	97,769.6	25,558.9
2105	Нормативт зардал	310,163.1	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,631.4	24,669.4
2107	Томилолт, зочны зардал	1,218.5	2,673.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,633.1	93,706.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	510,139.6	277,858.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,197,000.3	4,157.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,168,011.3	-53,143.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	34,121.6	9,969,361.7
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3,133,889.7	-10,022,504.9

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,001,628.1	1,364,640.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	133,547.4	306,891.1
110	Орлогын албан татвар	61,081.3	228,873.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	61,081.3	243,779.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-14,906.3
113	Хөрөнгийн албан татвар	37,917.5	46,666.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	34,548.5	31,351.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,385.8	4,221.4
1181	Газрын төлбөр	819.0	2,201.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	27,343.7	24,928.4
1183	Бусад татвар	0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	550,375.0	152,855.6
120	Нийтлэг татварын бус орлого	550,375.0	152,855.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,317,705.7	904,893.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,598,228.5	1,357,286.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,598,228.5	1,357,286.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,404,485.4	1,092,718.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,098,086.6	543,661.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	284,671.8	91,785.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	574,706.6	147,928.7
2104	Хангамж, бараа материалын зардал	167,380.6	174,561.8
2105	Нормативт зардал	119,061.6	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,793.6	24,669.4
2107	Томилолт, зочны зардал	1,218.5	2,673.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,784.0	68,893.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,782.0	38,545.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,193,743.1	264,568.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	403,399.6	7,353.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	243,938.9	66,822.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	243,938.9	66,822.0
2200	Дотоод эх үүсвэрээр	243,938.9	66,822.0
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-243,938.9	-66,822.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-7,000.0	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	7,000.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	152,460.7	-59,468.1
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	112,514.5	264,975.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	264,975.1	205,507.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,679,013.8	7,679,013.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,869,726.9	1,869,726.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,548,740.7	9,548,740.7
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-26,450.9	-26,450.9
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	12,182.5	12,182.5
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	3,133,889.7	3,133,889.7
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,668,362.0	12,668,362.0
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	12,668,362.0	12,668,362.0

12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-72,577.4	-72,577.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,595,784.6	12,595,784.6
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-4,957.5	-4,957.5
19	Тайлант үеийн үр дүн	-10,022,504.9	-10,022,504.9
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,568,322.2	2,568,322.2

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,440,971.10	1,321,042.82	119,928.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,375,971.10	1,321,042.82	54,928.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,095,777.20	1,059,827.02	35,950.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	387,158.40	382,207.16	4,951.24
210101	Үндсэн цалин	330,704.60	317,428.25	13,276.35
210102	Нэмэгдэл	52,953.80	57,260.75	-4,306.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00	0.00
210104	Урамшуулал	3,500.00	7,518.16	-4,018.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,651.40	47,986.65	664.75
210201	Тэтгэврийн даатгал	33,220.50	33,567.25	-346.75
210202	Тэтгэмжийн даатгал	4,156.50	3,958.96	197.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,005.50	2,735.92	269.58
210204	Ажилгүйдлийн даатгал	752.50	663.79	88.71
210205	Эрүүл мэндийн даатгал	7,516.40	7,060.74	455.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	529,045.90	521,106.32	7,939.58
210301	Гэрэл, цахилгаан	27,193.30	19,949.61	7,243.69
210302	Түлш, халаалт	497,204.20	497,175.31	28.89
210303	Цэвэр, бохир ус	4,648.40	3,981.40	667.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,281.20	24,728.88	552.32
210401	Бичиг хэрэг	2,700.00	2,676.50	23.50
210402	Тээвэр, шатахуун	17,299.20	17,215.69	83.51
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,360.00	2,988.29	371.71
210404	Ном, хэвлэл	422.00	348.40	73.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500.00	1,500.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,907.60	24,169.36	20,738.24
210604	Урсгал засвар	44,907.60	24,169.36	20,738.24
2107	Томиллолт, зочны зардал	3,248.70	2,673.00	575.70
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	3,248.70	2,673.00	575.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,884.00	20,460.00	424.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,949.00	18,649.00	300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	700.00	700.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	500.00	500.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	240.00	224.71	15.29
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	45.00	45.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	0.00	0.00
210807	Газрын төлбөр	450.00	341.30	108.71
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,600.00	36,495.64	104.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,500.00	35,500.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,100.00	995.64	104.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	280,193.90	261,215.80	18,978.10
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	245,478.10	226,500.00	18,978.10
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	245,478.10	226,500.00	18,978.10
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,715.80	34,715.80	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,693.20	3,693.20	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,522.60	30,522.60	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500.00	500.00	0.00

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	65,000.00	0.00	65,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	65,000.00	0.00	65,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,440,971.10	1,331,542.50	109,428.60
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	108,963.40	151,741.99	-42,778.59
310001	Улсын төсвөөс санхүүжих	0.00	0.00	0.00
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	108,963.40	151,741.99	-42,778.59
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,129,669.60	1,112,144.11	17,525.49
320001	Орон нутгийн төсвөөс	1,129,669.60	1,112,144.11	17,525.49
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	202,338.10	67,656.39	134,681.71
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,000.00	64,782.65	-39,782.65
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500.00	2,873.75	-1,373.75
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	175,838.10	0.00	175,838.10
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	157,917.53	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	149,615.92	

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,310.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,310.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,310.80
2104	Хангамж, бараа материалын зардал	830.00
210401	Бичиг хэрэг	280.00
210402	Тээвэр, шатахуун	550.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500.00
210604	Урсгал засвар	500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,930.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,930.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,050.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	150.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,900.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,310.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,730.8
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	780.00
131106	Хаагдсан данс	0.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	0.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Шинэ-Идэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн захирагч юм.

Шинэ-Идэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант хугацаанд “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Тус сумын Засаг дарга нь нь аймгийн Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 90.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн удирдлагын тухай хууль, Татварын багц хууль болон бусад хууль тогтоомж, журам зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх хяналтыг тавьж ажилласан байна.

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны байгууллагуудаас нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу Соёлын төв, Эрүүл мэндийн төв, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулж, Хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль тус тус улсын төсөвт шилжсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын дагуу Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/128 тоот захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын баг байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа, цаг ашиглалт, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зарцуулал, өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, орон нутгийн орлогын гүйцэтгэл, худалдан авах ажиллагаа, шилэн дансны мэдээлэл, Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголт зэрэг үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шинэ-Идэр сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шинэ-Идэр сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2005 оны 341 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зааврын"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,096.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	265.0	205.5	-59.5
Авлага	235.7	123.8	-111.9
Бараа материал	436.4	76.9	-359.5
Урт хугацаат зээлийн авлага	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгө	11,733.4	2,167.8	-9,565.6
Нийт хөрөнгө	12,670.4	2,574.0	-10,096.4
Өр төлбөр	2.0	5.7	3.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	12,668.4	2,568.3	-10,100.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	12,670.4	2,574.0	-10,096.4

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдэж бараа материал, үндсэн хөрөнгө, авлага, өглөгийн дансны үлдэгдлүүд буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 59.5 сая төгрөгөөр буурсан бөгөөд Орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 50.5 сая төгрөг, ОНХС-ийн дансны үлдэгдэл 19.0 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэл 130.6 сая төгрөг, Шинэ-Идэр Эрдэнэт дулаан ХХК-ийн дансны үлдэгдэл 5.4 сая төгрөг нийт 205.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Дээрх мөнгөн хөрөнгийн 200.1 сая төгрөг нь Төрийн сангийн харилцах дансанд, 5.4 сая төгрөг нь арилжааны банкны харилцах дансанд байршиж байна.
2. Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 111.9 сая төгрөгөөр буурсан бөгөөд Шинэ-Идэр Эрдэнэт дулаан ХХК-ийн борлуулалтын авлага 15.6 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага 108.2 сая төгрөг байна. Хоршоо хөгжүүлэх сангийн 23 иргэний 69.5 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 361 дүгээр тушаалаар баталсан "хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1 дэх "орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.
3. Бараа материалын дансны үлдэгдэл буурахад Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв гэсэн 4 байгууллагын тайланг улсын төсөвт шилжүүлэн нэгтгэсэн нь нөлөөлсөн байна.
4. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурахад буурахад Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв гэсэн 4 байгууллагын тайланг улсын төсөвт шилжүүлэн нэгтгэсэн нь нөлөөлсөн байна.
5. Өр төлбөрийн данс 3.7 сая төгрөгөөр өсөж 5.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна. Дээрх өглөг нь Шинэ-Идэр Эрдэнэт дулаан ХХК-ийн дансны өглөгийн дүн байна.

Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 2,680.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 5,377.8 сая төгрөгөөр буюу 33.3 хувиар буурсан байна.

Хүснэгт №2 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү
Татварын орлого	133.5	306.9	173.4
Татварын бус орлого	3564.1	-331.5	-3895.6
Тусламж санхүүжилтийн орлого	4360.9	904.9	-3456.0
Нийт дүн	8058.5	880.3	-7,178.2

Нийт орлогын дүн буурсан шалтгаан нь боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагууд улсын төсөвт шилжиж улсын төсвөөс авах санхүүжилт хасагдсанаас шалтгаалсан байна.

Шинэ-Идэр Эрдэнэт дулаан ХХК-ийн нийт ашгийн дүнг татварын бус орлогын хэсэгт тусгасны улмаас санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн татварын бус орлогын дүн -331.5 сая төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын 1,574.6 сая төгрөгийн орлогын давхардсан 11 гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар тайлант онд 10,902.8 сая төгрөгийн зардлыг хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.

Хүснэгт №3: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/сая төгрөгөөр/ зөрүү
Үйл ажиллагааны зардал	4,890.6	933.4	-2,957.2
Үйл ажиллагааны бус зардал	34.1	9,969.4	9,935.3
Нийт дүн	4924.7	10,902.8	5,978.1

Эх сурвалж: Шинэ-Идэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Нийт зардлын дүн өссөн нь гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих байгууллагуудын үндсэн хөрөнгө, бараа материалыг улсын төсөвт шилжүүлэхдээ үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын 1,574.6 сая төгрөгийн зарлагын давхардсан 11 гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төслийг харьяа байгууллагуудын хүрээнд нэгтгэн боловсруулж орон нутгаас санхүүжүүлэх Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн байгууллагуудын тогтмол зардлыг тусгаж дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Шинэ-Идэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 14 хөтөлбөрт зориулан 1,421.8 сая төгрөгийн төсөв баталснаас 1,059.8 сая төгрөгийг урсгал зардалд, 259.5 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, Эргэж төлөгдөх зээлийн зардалд 66.5 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 125.7 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, санхүүгийн дэмжлэгээс 806.2 сая төгрөгийг, сумын орон нутгийн орлогоос 304.4 сая төгрөгийг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 26.5 сая төгрөгийг, давсан орлого дансны үлдэгдлээс 175.8 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант онд Шинэ-Идэр сумын ИТХ-ын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор төсөвт тодотгол хийж төсвийг 1,489.1 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн орлогын гүйцэтгэл

Гүйцэтгэлээр Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 67.7 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 1,112.1 сая төгрөгийг, орон нутгийн хөгжлийн сангаас 151.7 сая төгрөгийг, нийт 1,331.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Шинэ-Идэр сумын ИТХ-ын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 09 дүгээр тогтоолд зааснаар Шинэ-Идэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 304.4 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 319.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 105 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №4. Төвлөрүүлэх орлого

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	159.6	184.2	24.6	115%
Үйл ажиллагааны орлого	10.3	18.6	8.3	181%
Хөрөнгийн орлого	30.0	28.6	(1.4)	95%
Хөрөнгө борлуулсны орлого	8.0	9.1	1.1	114%
Шууд бус орлого	14.3	3.2	(11.1)	22%
Буцаан олголт	(14.9)	(14.9)	-	100%
Бууны албан татвар	4.7	4.0	(0.7)	85%
Үл хөдлөх албан татвар	8.8	2.1	(6.7)	24%
Малд ногдуулах албан татвар	40.0	40.5	0.5	101%
Улсын тэмдэгтийн хураамж	4.0	4.0	-	100%
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.2	0.2	-	100%
Газрын төлбөр	2.5	2.2	(0.3)	88%
Ойн нөөц ашигласны төлбөр	23.6	24.2	0.6	103%
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.1	-	(0.1)	0%
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.5	0.6	0.1	120%
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	0.1	0.2	0.1	150%
Хувьцааны ногдол ашиг	7.0	7.0	-	100%
Торгуулийн орлого	4.0	3.7	(0.3)	93%
Бусад орлого	1.2	1.5	0.3	125%
Түрээсийн орлого	0.4	0.4	-	100%
НИЙТ ОРЛОГО	304.4	319.4	14.95	105%

Эх сурвалж: Шинэ-Идэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Шинэ-Идэр сумын орон нутгийн орлогын төлөвлөгөө 15.0 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татвар 24.6 сая төгрөгөөр, үйл ажиллагаа эрхэлсний орлогын татвар 8.3 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрөл бүрээр хянаж үзэхэд 7 төрлийн орлого нийт 20.6 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 17.3 сая төгрөгөөр төлөвлөж, 17.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 100.1 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №5: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	4.0	3.5	-0.5
2	Түрээсийн орлого	0.5	0	-0.5
3	Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар	9.6	10.9	1.3
4	Зам ашигласны төлбөр	3.2	3.0	-0.2
	Нийт дүн	17.3	17.4	0.1

Эх сурвалж: Шинэ-Идэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 0.1 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 50.4 сая төгрөгөөр төлөвлөж, 75.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 150.6 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №6: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

				/сая төгрөгөөр/
№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	3.9	3.4	-0.5
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	45.7	70.2	24.5
3	Агаарын бохирдлын төлбөр	1.0	2.1	1.1
Нийт дүн		50.6	75.7	25.1

Эх сурвалж: Шинэ-Идэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 25.1 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Тусламж санхүүжилтийн орлогын талаар

Тайлант онд тусламж санхүүжилтийн орлогыг 1,129.7 сая төгрөгөөр төлөвлөж, 1,112.1 сая төгрөг буюу 98.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 26.5 сая төгрөгийг орлогыг оруулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 67.7 сая төгрөгийн хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлтийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Төсвийн зарлагын талаар:

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 14 хөтөлбөрт зориулан 1,440.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,116.4 сая төгрөгийг урсгал зардалд, 259.5 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 65.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр урсгал зардалд 1,059.8 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 245.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,321.0 сая төгрөг буюу 91.7 хувьтай байгаа нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олгоогүйтэй холбоотой байна.

ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлэх 5 төсөл арга хэмжээнд 259.5 сая төгрөг батлагдсанаас 245.4 сая төгрөгийг зарцуулж мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 18.9 сая төгрөг болсон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд ТТЗ-ийн харьяа байгууллагууд нь хандив тусламжаар 0.8 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 4.7 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 0.8 сая төгрөг, нийт 6.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Дээрх нэмэлт санхүүжилтийн орлогуудыг удирдамж зориулалтын дагуу зарцуулж ажилласан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шинэ-Идэр сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Л.Мандахнаран гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Шинэ-Идэр сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1/104 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 1.5 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 49.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 39.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлж нийт зардлын хэмжээ буурсан тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоов.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 1,122.7 сая төгрөгийг сонгож 13.5 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Шинэ-Идэр сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 93.2 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт №7 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	3	93.2	3	93.2	100
Нийт дүн	3	93.2	3	93.2	100

Өмнөх онд хүргүүлсэн 3 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 90.1 сая төгрөгийн зөрчил илэрч зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг хүргүүлсэн.

ТТЗ-ийн Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 57.8 сая төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрсэн байна. Төсвийг зориулалт бусаар зарцуулсан 1 зөрчилд 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 57.0 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн байна.

5.1 Төлбөрийн акт

ТТЗ-ийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

ТТЗ-ийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлийн аудитаар албан шаардлага өгөөгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй холбоотой асуудлын талаар

1.1. Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн 23 иргэнтэй холбоотой 69.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021оны 361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах.

2. Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрөл бүрээр авч үзвэл 7 нэр төрлийн 20.6 сая төгрөгийн орлогыг дутуу биелүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөж, нэр төрөл бүрээр төлөвлөгөөг биелүүлж ажиллах

3. ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн зөрчлийн талаар

3.1. Илрүүлэлт:

ТТЗ-ийн Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 70.9 сая төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрсэн байна. Төсвийг зориулалт бусаар зарцуулсан 1 зөрчилд 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 70.6 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Өөрийн хяналтад байдаг байгууллагуудын санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжүүдийг хяналтдаа авч хэрэгжилтийг хангуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлого бүрдүүлэлттэй холбоотой	1	20.6					1	20.6				
Хугацаа хэтэрсэн зээлийн авлага	1	69.5					1	69.5				
Харьяа байгууллагуудын зөрчил	1						1					
Дүн	2	90.1					1	90.1				
Харьяа байгууллагуудын зөрчил												
Шинэ-Идэр Эрдэнэт дулаан ХХК	4	70.6					4	70.6				
Шинэ-Идэр сумын ИТХ	1	0.3	1	0.3								
Дүн	5	70.9	1	0.3			4	70.6				

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
 АУДИТЫН МЕНЕЖЕР
 БАТАЛГААЖУУЛСАН:
 АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ:

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Л.МАНДАХНАРАН ОГНОО: